

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нарийнтээл сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2023/11/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2023 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ
ТӨРИЙН АУДИТЫН АГАЗАР

Төрийн үйлчилгээний үйлчилгээний төв
Бидний үйлчилгээний төв
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 7711 3111, 7711 3112
Мэдээллийн үйлчилгээний төв
Электрон хуудал: www.audit.mn

Хягууртлага № 135
Хягууртлага № 135

НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б СУГАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нарийнтээл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нарийнтээл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нарийнтээл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болсон. Тухайлбал:

- Эрсдэлээс хамгаалах сангийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 12.0 сая төгрөгөөр автомашин худалдан авсан.
- Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэр төрлөөр батлуулаагүй
- Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар шинэчлэн баталсан анхан шатны баримтаар хөтлөөгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.6.6 "төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд сумын ЕБС, Цэцэрлэг, Соёлын төв нь улсын төсөвт байгууллага болж өөрчлөгдсөнтэй холбоотой тус байгууллагуудын эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгүүдийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлсэн байна.

015030769

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Нарийнтээл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Баянтээг багийн ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн 5 312 7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 220.5 сая төгрөгийн бараа материал, 9.0 сая төгрөгийн авлага, өглөгийг улсын төсөвт төвлөрүүлж хаалтын бичилт хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,053,344.9	707,503.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,765,370.9	2,564,433.5
Нийт хөрөнгийн дүн	8,818,715.8	3,271,936.9
Нийт өр төлбөрийн дүн	226,654.6	137,825.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,592,061.3	3,134,111.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,818,715.8	3,271,936.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	5,691,359.3	2,313,677.7
Үйл ажиллагааны зардлын дүн	5,231,840.2	1,379,850.5
Үйл ажиллагааны үр дүн	459,519.1	933,827.1
Үйл ажиллагааны бус үр дүн	(17,694.5)	(6,391,777.4)
Үйл ажиллагааны нийт үр дүн	441,824.7	(5,457,950.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,150,236.6	10,650,603.6
Тайлант оны үр дүн	441,824.7	(5,057,950.3)
Эцсийн үлдэгдэл	8,592,061.3	3,134,110.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,914,060.6	1,555,288.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,414,464.5	1,174,201.3
Үйл ажиллагааны ЦМГ	499,596.2	381,087.5
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(207,569.1)	349,769.1
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(76,266.5)	(765,200.0)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	215,760.6	30,553.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	191,218.2	409,938.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	405,443.9	440,491.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,902,253.1	1,469,591.0
Урсгал зардал	1,262,805.1	1,133,071.7
Хөрөнгийн зардал	475,448.0	335,754.1
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,326,877.2	1,341,713.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,012.9	1,306,701.3
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	198,500.4	198,500.4
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	294,000.0	133,380.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,000.0	17,590.5
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 4 зөрчил¹ илэрч, 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

3.2 Албан шаардлага

1. Эрсдэлээс хамгаалах сангийн Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 12000.0 мянган төгрөгөөр автомашин худалдан авсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 тоот тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7-д "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шийдвэр гаргалт, үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн байгууллагын захирал, эрхлэгч нарт үр дүнгийн урамшуулал олгохдоо 3 сайдын хамтарсан тушаалаар баталсан ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын төсвийн байгууллагын захирал, эрхлэгч нарын ур чадварын нэмэгдэл олгохдоо 3 сайдын хамтарсан ур чадварыг олгох шалгуур үзүүлэлтийг мөрдөж ажлын хэсгийн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн олгож байх.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэр төрлөөр батлуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6. "төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэр төрлөөр батлуулж зориулалт арга хэмжээ бүрээр зарцуулж байх.

3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ		1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ		1				1		

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143631
ИНОА0059 9044094